

**Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын Үндэсний
зөвлөлийн хуралдааны тэмдэглэл**

2010 оны 6 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 7

Улаанбаатар
хот

Хуралдааныг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд, Үндэсний зөвлөлийн орлогч
дарга Д.Зоригт удирдав.

I. ХЭЛЭЛЦСЭН нь: Харт Нойрс групп болон Улаанбаатар корпораци ХХК-
ийн гаргасан Монгол Улсын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын
санаачилгын 2008 оны аудитын нэгтгэсэн тайлан

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Харт Нойрс лтд болон Улаанбаатар корпораци
ХХК-ийн гаргасан Монгол Улсын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын
санаачилгын 2008 оны аудитын нэгтгэсэн тайланг дэмжиж хуралдаан дээр
гишүүдийн гаргасан саналыг тусган батлахаар тогтов.

2. Тайлангаар шийдэгдээгүй 420 сая орчим төгрөгийн зөрүүг Үндэсний
аудитын газар энэ онд багтаан хянан шалгаж дүнг Үндэсний зөвлөлийн
хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын Ерөнхий аудитор, Үндэсний зөвлөлийн
гишүүн Ч.Раднаад зөвлөмж болгов.

3. Энэхүү тайланг Монгол Улсын ОҮИТБС-ын ажлын албаны вебсайт болон
Сангийн яам, Эрдэс баялаг, эрчим хүчний яам, Монголын уул уурхайн ассоциаци,
Нээлттэй нийгэм форумын вебсайтад тус тус тавьж нийтэд ил тод болгох нь
зүйтэй гэж үзэв.

4. Тайланг ОҮИТБС-ын олон талт оролцогчдын уулзалтаар хэлэлцүүлэхийг
Үндэсний зөвлөлийн 3 талын төлөөлөл Эрдэс баялаг, эрчим хүчний сайд
Д.Зоригт, Монголын уул уурхайн ассоциацийн Ерөнхийлөгч Дамба, Нээлттэй
нийгэм форумын гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал нарт үүрэг болгож,
хэлэлцүүлэг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэхийг Ажлын албаны зохицуулагч
Ш.Цолмонд даалгав.

5. Тайлан гаргах маягт, заавар, нийтэд мэдээлэх журмыг боловсруулж
байгаа ажлыг шуурхайлж ойрын үед дуусган холбогдох яам, байгууллагад
хүргүүлж батлуулахыг ОҮИТБС-ын ажлын алба, тайлан гаргах маягт боловсруулж
байгаа ажлын хэсэгт даалгав.

6. Тайлан гаргах чиглэлээр яам, агентлаг, аймаг, нийслэлийн холбогдох
нэгж, ажилтнуудад зориулсан сургалтыг Сангийн яам хариуцан Ажлын албатай
хамтран зохион байгуулах, тэдэнд зөвлөгөө, заавар чиглэл өгч ажиллахыг
Сангийн сайд, Үндэсний зөвлөлийн гишүүн С.Баярцогтод үүрэг болгов.

7. Монголын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын Монгол
Улсын гурав дахь удаагийн буюу 2008 оны нэгтгэлийн тайланг судалж, байгаль
хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардлын зөрүүний шалгааныг тогтоож,
байгаль хамгаалах ажлын зардал тооцох, тайлан гаргах, тайлангийн мөрөөр
тодорхой арга хэмжээ авч ажиллан үр дүн, цаашид авах арга хэмжээний саналаа
ОҮИТБС-ын Үндэсний зөвлөлийн 9 дүгээр сарын хуралдаанд танилцуулахыг

Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хариуцуулж, энэ ажлын явцад хяналт тавьж ажиллахыг Үндэсний зөвлөлийн гишүүн, Хүний эрх, хөгжил төвийн тэргүүн Г.Уранцоож, Үндэсний зөвлөлийн гишүүн, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны ерөнхийлөгч Л.Нямсамбуу нарт даалгав.

8.Компаний тайланг цахим хэлбэрээр гаргах бэлтгэлийг Ажлын алба, яам, агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүргийн тайланг цахим хэлбэрээр гаргах бэлтгэлийг Сангийн яам, Татварын ерөнхий газар хангаж, цаашид тайлан гаргах үйл ажиллагааг хөнгөвчлөхөөр тогтов.

9.Монгол Улсын гурав дахь удаагийн буюу 2008 оны нэгтгэлийн тайланд орсон ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч бүрийн уулын ажлын төлөвлөгөөний биелэлтийг олборлосон ашигт малтмал, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулсан дүн, улс болон орон нутагт оруулсан орлого (тайлангийн Засгийн газрын гаргасан мэдээ), улс болон орон нутагт төлсөн татвар төлбөр (тайланд компанийн гаргасан мэдээ)-тэй уялдуулан Татварын ерөнхий газар, Ажлын албанаас арга зүйн зөвлөлгөө авч шалган, дүнг цаашид авах арга хэмжээний саналын хамт Үндэсний зөвлөлийн энэ оны 9 дугээр сарын хуралдаанд танилцуулахыг Ашигт малтмалын газрын дарга, ОУИТБС-ын Ажлын хэсгийн гишүүн Батхуягт даалгав.

10. Монгол Улсын нэгдсэн тайланд компаниас өгсөн хандив тусламж, тайлангаар гарсан зөрүүг яам, агентлаг, байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн нэрээр гаргадаг байхаар аудитор шалгаруулах удирдамжид тусгаж байхаар тогтов.

11. Ажлын албанаас тайланг компани нэг бүрээр хураангуй байдлаар гаргаж байгааг дуусган, мөн тайлангаар үүссэн зөрүүг татвар, төлбөр, хандив тусламжийн нэр төрлөөр нь яам, агентлаг, байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүрэг бүрээр гаргаж Үндэсний зөвлөлийн гишүүдэд ажил хэргийн шугамаар танилцуулж, нийтэд сурталчлахаар тогтов.

12. Монгол Улсын гурав дахь удаагийн буюу 2008 оны нэгтгэлийн тайлангаар зөрүү гаргаагүй, зөрүүг тодруулах үйл ажиллагаанд ажил хэрэгч хандсан компанийн удирдлагад талархал илэрхийлэхээр тогтов.

13. Монгол Улсын гурав дахь удаагийн буюу 2008 оны нэгтгэлийн тайлангийн талаар ОУИТБС-ын Ажлын албатай хамтран нийтэд мэдээлж ажиллахыг Засгийн газрын хэвлэл мэдээллийн албандаа даалгав.

II. ХЭЛЭЛЦЭН нь: Монгол Улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын баталгаажуулалтын тайлангийн талаар ОУИТБС-ын Удирдах хорооноос гаргасан шийдвэр, түүнийг хэрэгжүүлэх талаар зохион байгуулж байгаа ажлын явцын тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1.Монгол Улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын баталгаажуулалтын тайлангийн талаар ОУИТБС-ын Удирдах хорооноос гаргасан шийдвэр, түүнийг хэрэгжүүлэх талаар зохион байгуулж байгаа ажлын явцыг эрчимжүүлж, явцыг Ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцэн дүгнэж, улмаар Үндэсний зөвлөлийн гишүүдэд танилцуулж байхыг

Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Долгорт үүрэг болгов.

2. Монгол Улсын ОУИТБС-ын нэгдсэн тайлан гаргах болон бусад зардлыг улсын төсөвт тусгах асуудлыг Засгийн газарт танилцуулж шийдвэр гаргуулах нь зүйтэй гэж үзэв.

3. Монгол Улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын баталгаажуулалтын тайлангийн талаар ОУИТБС-ын Удирдах хорооноос гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх талаархи ажлын дүнг Үндэсний зөвлөлийн дараагийн хуралдаанаар хэлэлцэхээр тогтов.

III. ХЭЛЭЛЦСЭН нь: Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацаа (2010-2014 он)-ны стратеги батлах тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1.Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацаа (2010-2014 он)-ны стратегийн төслийн төслийг дэмжиж, хуралдаан дээр гишүүдийн гаргасан саналыг тусган батлахаар тогтов.

2.Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацаа (2010-2014 он)-ны стратегийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, биелэлтийг Үндэсний зөвлөлд жил бүрийн 1 дүгээр улиралд танилцуулж байхыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Долгор нарт хариуцуулав.

3. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын хэрэгжилт, цаашид баримтлах бодлогын талаар Олон улсын бага хурлаар хэлэлцэх үед тайлангийн аудитыг үндэсний компаниар хийлгэх, үндэсний аудитор, үндэсний баталгаажуулагчтай болох зэрэг саналыг уламжлан хэлэлцүүлэх талаар хуралдаан дээр гарсан саналыг уламжлан шийдвэрлүүлэхийг Олон улсын удирдах хорооны гишүүн Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Нээлттэй нийгэм форумын менежер Н.Дорждарь нарт хариуцуулав.

IV. ХЭЛЭЛЦСЭН нь: Төлбөрийн материаллаг байдлыг тооцох талаар баримтлах арга зүйн танилцуулга

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1.Материаллаг төлбөрт дараах татвар, төлбөр, хураамж, шимтгэл, хандив тусlamжийн төлбөр, орлогыг оруулан тогтоохоор тогтов:

1.1.Хувь хүний орлогын албан татвалаас бусад бүх албан татвар (аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хөрөнгийн орлогын албан татвар, үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлогын албан татвар, нэмэгдсэн өргтийн албан татвар, зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар (зөвхөн 2010 онд), гаалийн албан татвар, онцгой албан татвар (шатах тослох материал импортолсон бол), автобензин, дизелийн түлшний албан татвар, үл хөдлөх эд, хөрөнгийн албан татвар, автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар, цөмийн төхөөрөмж барих, өөрчлөх, шинэчлэх, ашиглалтаас гаргах, ашиглах тусгай зөвшөөрөл олгоход хураах улсын тэмдэгтийн хураамж, цөмийн бодис эзэмших, ашиглах,

худалдах, импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах тусгай зөвшөөрөл олгоход хураах улсын тэмдэгтийн хураамж, цацраг идэвхт ашигт малтмал импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах, ашиглалтын дараа газар нөхөн сэргээх тусгай зөвшөөрөл олгоход хураах улсын тэмдэгтийн хураамж, цацрагийн үүсгүүрийг эзэмших, ашиглах, худалдах, угсрал, байрлуулах, түрээслэх, үйлдвэрлэх, ашиглалтаас гаргах, задлах, хадгалах, тээвэрлэх импортлох, экспортлох, хаягдлыг булшлах, идэвхийг сулруулах болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход хураах улсын тэмдэгтийн хураамж, түүний орлого;

1.2.Хууль тогтоомжоор тогтоогдсон бүх төрлийн төлбөр (ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр, улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр, газрын төлбөр, ус ашигласны төлбөр, ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр), орлого;

1.3.Хууль тогтоомж, шийдвэрийн дагуу хурааж байгаа хураамж (гаалийн үйлчилгээний хураамж, төрийн захиргааны бүх шатны байгуулагад төлсөн тэмдэгтийн хураамж болон үйлчилгээний хөлс);

1.4.нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн аж ахуйн нэгжээс төлж байгаа шимтгэлийн төлбөр, орлого;

1.5.Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу Засгийн газарт ногдох газрын тосны төлбөр, орлого, үүнээс роялти, мөн гэрээний дагуу төлж байгаа бусад төлбөр, дэнчин, урамшуулал (гэрээнд гарын үсэг зурсны урамшуулал, олборлолт эхэлсний урамшуулал, тухайн жилийн сургалтын урамшуулал, талбайн дэнчин, захиргааны үйлчилгээний шимтгэлүүд, төлөөлөгчийн газрыг дэмжих үйл ажиллагааны зардал, орон нутгийг дэмжих үйл ажиллагааны зардал)-ын төлбөр, орлого;

1.6.Төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашгийн төлбөр, орлого;

1.7.Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд төвлөрүүлсэн хөрөнгө;

1.8.Эрх бүхий албан тушаалтан,(сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга, эрх бүхий улсын байцаагч)-ы зөрчил гаргасан байгууллага, аж ахуйн нэгжийг торгох шийтгэлийн төлбөр, орлого;

1.9.Яам, агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүрэг зэрэг төрийн захиргааны бүх шатны байгууллагад өгсөн Засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний хэмжээнээс дээш хэмжээний хандив тусlamж (мөнгөн болон материаллаг хандив тусlamж)ийн төлбөр, орлого.

2. Энэхүү тэмдэглэлийн 1 дүгээр зүйлд заасан татвар, төлбөр, хураамж, шимтгэл, торгууль, хандив тусlamжийг нэр төрлөөр нь ОҮИТБС-ын тайлангийн маягт (Маягтуудын төслийг хавсаргав)-ад оруулан батлуулахыг Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Долгор, Ажлын алба (Ш.Цолмон)-нд даалгав.

3.Материаллаг төлбөрийн тайлагнах доод хэмжээ нь татвар, төлбөр, хураамж, бусад орлогын нэр төрөл бүр дээр 10.0 мянган төгрөг (Тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 5.8, 13.1-д аж ахуйн нэгжийг бүртгэх, гэрчилгээ олгох төлбөр 10000 төгрөг)-өөс дээш хэмжээний татвар, төлбөр, хураамж, үйлчилгээний хөлс, хандив тусlamж, түүний орлогыг хамруулах нь зүйтэй гэж үзэв.

4. Яам, агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүрэг зэрэг төрийн захиргааны бүх шатны байгууллагад өгсөн Засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний хэмжээнээс дээш хэмжээний хандив тусламж (мөнгөн болон материаллаг хандив тусламж), түүний орлогыг аудитаар баталгаажуулж байх нь зүйтэй гэж үзэв.

5. Захиргааны шийтгэлийн байгууллага, аж ахуйн нэгжид ногдуулсан нэг удаагийн 50000 төгрөг (торгох шийтгэлийн доод хэмжээ)-өөс дээших торгууль, түүний орлогыг аудитаар баталгаажуулах нь зүйтэй гэж үзэв.

6. Төлбөрийн материалаг байдал буюу татвар, төлбөрийн нийлбэр дүнгээр 50.0 сая төгрөгөөс дээш материаллаг орлого бүхий аж ахуйн нэгжийг олон улсын аудит оролцсон хөндлөнгийн аудитад хамруулах нь зүйтэй гэж үзэв.

7. Харин 10.0-50.0 сая төгрөг хүртэлх хэмжээний материаллаг орлого оруулсан компанийн тайланг дотоодын аудитын компаниар аудит хийлгэж байхаар тогтов.

8. ОҮИТБС-ын тайлангийн маягт, түүнийг гаргах заавар боловсруулах, аж ахуйн нэгж, төрийн захиргааны байгууллагууд тайлан гаргах үед материаллаг төлбөр, орлогын материаллаг байдлыг тогтоохдоо олон улсын нягтлан бодох бүртгэл (санхүүгийн тайлагналын)-ийн стандартын материаллаг байдлын тодорхойлолт, стандартыг дагаж мөрдөхөөр тогтов.

9. Монгол Улсын нэгдсэн тайлан гаргаж байгаа аудитын компани төлбөрийн материаллаг байдлыг тогтоохдоо Аудитын олон улсын стандарт, түүнийг дагаж мөрдөхөөр гаргасан дотоодын дүрэм, журмыг ОҮИТБС-ын Ажлын хэсэгт танилцуулан мөрдөж байхаар тогтов.

10. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн үзэл баримтлал, хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн үйл ажиллагаанд хяналт тавьж, Улсын Их Хурлын намрын нэгдсэн чуулганд хэлэлцүүлэхээр төлөвлөж ажиллахыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд, Үндэсний зөвлөлийн орлогч дарга Д.Зоригтод даалгав.

Ү. ХЭЛЭЛЦСЭН нь: Засгийн газар болон компаниудын ОҮИТБС-ын 2009 оны тайлан гаргах ажлын явцын тухай.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. ОҮИТБС-ын 2009 оны тайлангаа гаргаагүй байгаа компаниудын нэrsийг төвийн өдөр тутмын хэвлэлд гаргахыг Ажлын албаны зохицуулагч Ш. Цолмонд даалгав.

2. 2010 оны 7 дугаар сарын 1- нээр тасалж, тайлан гаргаагүй компаниудын тухай судалгааг гаргаж, торгуулийн хариуцлага тооцуулах зөвлөмжийг Ашигт малтмалын газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт хүргүүлэхийг Ажлын албаны зохицуулагч Ш. Цолмонд даалгав.

3. Засгийн газрын 2009 оны ОҮИТБС-ын нэгдсэн тайланд мэдээгээ ирүүлээгүй төрийн захиргааны зарим байгууллагуудын удирдлагад үр дунгийн гэрээний дагуу анхааруулга өгөх арга хэмжээ авахыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд, Үндэсний зөвлөлийн орлогч дарга Д.Зоригт, Сангийн сайд, Үндэсний зөвлөлийн гишүүн С.Баярцогт наарт даалгав.

4. Монгол Улсын ОҮИТБС-ын 2009 оны аудитын тайлан гаргах аудитын компанийн консерциумыг сонгон шалгаруулах тендерийг 2010 оны 7 дугаар сард багтаан зохион байгуулахыг Сангийн сайд, Үндэсний зөвлөлийн гишүүн С.Баярцогт, Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Долгор, Ажлын албаны зохицуулагч Ш. Цолмон нарт даалгав.

5. Монгол Улсын ОҮИТБС-ын 2009 оны аудитын тайлан гаргах аудитын компанийн консерциумын зардлын зарим хэсгийг улсын төсвөөс гарган санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд, Үндэсний зөвлөлийн гишүүн С.Баярцогт, Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Долгор нарт даалгав.

Танилцсан:

Монгол Улсын Ерөнхий сайд,
Үндэсний зөвлөлийн дарга

*Ерөнхий сайд
танилцсан дарга.*

С.БАТБОЛД

Хуралдааныг удирдсан:

Эрдэс баялаг, эрчим хүчний сайд,
Үндэсний зөвлөлийн орлогч дарга

Д.Зоригт

Д.ЗОРИГТ

Ерөнхий сайдын ахлах зөвлөх,
Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга

Б.Долгор

Б.ДОЛГОР